



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Гүйцэтгэлийн аудитын тайлан

Говьсүмбэр аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар,
Халамжийн сангийн 2016 оны үйл ажиллагааны үр дүн



**Нийгмийн халамжийн үйлчилгээнд хуулиар
тодорхойлсон иргэдийг бүрэн хамруулахад
шаардлагатай судалгаа, шинжилгээний
ажил хийгдээгүй байна.**

2017 он

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u> Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар Дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа Аудитор Г.Наранбаяр 2017 оны 04 дүгээр сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7054-3151, 7054-3156, 7054-3179 дугаарын утсаар харилцана уу. ХАЯГ: Аймгийн Засаг даргын тамгын газрын байр, 2 давхар, 208 тоот	Товчилсон үгийн тайлбар4 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....5 БҮЛЭГ 1. Байгууллагын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй, шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон байна. 1.1 Үйл ажиллагааны үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд батлагдсан орон тоонд хүний нөөцийг бүрэн ажиллуулаагүй байна. 1.2 Бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор төсвийн зардлын төлөвлөлт хийгдээгүй, тооцоо судалгаа байхгүй байна. 1.3 Орон тоо дутуу ажилласнаас бий болсон 4,411.2 мянган төгрөгийн үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлээгүй, зориулалт бусаар зарцуулж, төсвийн үр ашгийг бууруулсан байна. 1.4 Үндсэн хөрөнгийн шинж чанартай 9,619.0 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэж тайлагнасан байна. 1.5 Ашиглах боломжгүй болсон 30,000.0 мянган төгрөгийн зураг төсвийн үнэ нийт үндсэн хөрөнгийн 14.0 хувийг эзэлж байна. 1.6 Байгууллагын үндсэн чиг үүргийн хэрэгжилт, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна. 1.7 Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээллийг хугацаа хоцроосон байна. БҮЛЭГ 2: Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэдийн судалгааг бүрэн гаргаж, холбогдох байгууллагуудтай ажлын уялдаа, холбоогоо сайжруулах шаардлагатай байна. 2.1. Халамжийн сангийн төсвийг үндэслэлтэй төлөвлөж, батлуулаагүй байна. 2.2. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хуулиар тодорхойлсон иргэдийг бүрэн хамруулахад шаардлагатай судалгаа, шинжилгээний ажил хийгдээгүй байна. 2.3. Халамжийн сангийн төсвийн зарцуулалт жил бүр 75.9-81.8 хувьтай байгаа нь зорилтот бүлгийн иргэдийг бүрэн хамруулаагүй, төсвийг үндэслэлтэй төлөвлөж, батлуулаагүйтэй холбоотой байна. 2.4. Халамжийн сангийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.
--	---

	2.5. Бүртгэл мэдээллийн нэгдсэн санд Халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн мэдээллийг бүрэн оруулсан байна. 2.6. Халамжийн сангийн 5 төрлийн мэдээ, тайланг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн байна. Дүгнэлт Зөвлөмж Зөрчлийн нэгтгэл
--	---

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
МУЗГ	Монгол улсын Засгийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ГСА	Говьсүмбэр аймаг
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
НХҮЕГ	Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар
НХҮХ	Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ҮАЗ	Үйл ажиллагааны зардал

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторт Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газраас 2017 онд нийлүүлэх аудитын болон ажил, үйлчилгээний төлөвлөгөө, аймгийн ИТХ-ын захиалгыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Говьсүмбэр аймаг дахь Төрийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

2. Аудитын зорилго, зорилт

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Халамжийн сангийн 2016 оны үйл ажиллагааны үр дүнд Гүйцэтгэлийн аудит хийж, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмж гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдлээ.

3. Аудитын хамрах хүрээ

Аудитад Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Халамжийн сангийн 2016 оны үйл ажиллагааны тайлан, төсвийн төлөвлөлт, зарцуулалт, бүртгэл тайлагналтай холбоотой анхан шатны баримтууд, мэдээ судалгаа, холбогдох ажилтнуудтай хийсэн ярилцлага, бусад материалуудыг хамрууллаа.

4. Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад асуудлыг шинжлэхдээ аудитыг АДБОУС 100-400, 4200, Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, холбогдох журмуудыг ашиглахаас гадна холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, шаардлагатай мэдээ, судалгааг гаргуулан авч, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан, нотлох зүйл цуглуулж аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

5. Аудитын бүрэлдэхүүн

Аудитыг дарга,Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ц.Батсайхан, аудитор Г.Наранбаяр нар гүйцэтгэлээ.

6. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл

Аудитын тайлан нь аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, хавсралт гэсэн агуулгаар үндсэн зорилтын дагуу бичигдсэн.

Бүлэг 1

Байгууллагын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт
хангалтгүй, шилэн дансны мэдээллийг хугацаа
хоцроосон байна.

1.1. Үйл ажиллагааны үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд батлагдсан орон тоонд хүний нөөцийг бүрэн ажиллуулаагүй байна.

Аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс нь 2016 онд тусгайлан зорилт дэвшүүлж ажиллаагүй бөгөөд 2014 онд баталсан байгууллагын стратегийн төлөвлөгөөний дагуу дараах зорилтуудын хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, үр дүнгийн гэрээ байгуулан ажилласан байна. Үүнд:

1. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж үйлчилгээг зорилтот бүлэгт түргэн шуурхай, хүнд сурталгүй, чанартай хүргэх, халамж, асрамжийн шинэ үйлчилгээ, менежментийг нэвтрүүлэх, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоотойгоор үйлчилгээг чанартай хүргэх,
2. Хүн амын бүлгүүдийг дэмжих төрийн бодлогын хэрэгжилтийг хангах,
3. Хяналт шинжилгээ, үнэлгээний механизмыг боловсронгуй болгох,
4. НХҮЕГ, хэлтсүүдийн санхүүгийн хэвийн үйл ажиллагааг хангах, хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын багцад тусгагдсан нийгмийн халамжийн сангийн хуваарилагдсан хөрөнгийг зорилтот бүлэгт хүргэх,
5. Захиргаа хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, байгууллагын үйл ажиллагааг шинэ шатанд гаргахад удирдлагын манлайллыг хангаж, ил тод, авлига, хүнд сурталгүй үйлчилгээ, харилцааг төлөвшүүлж ажиллах

Тайлант онд тус хэлтэс нь 6 бүлэг, 48 ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөж, НХҮЕГ-ын дарга болон аймгийн Засаг даргатай үр дүнгийн гэрээ байгуулан, 2016 онд хийх ажлын төлөвлөгөөг батлуулсан байна.

2016 оны эхний хагас жилийн үр дүнгийн гэрээний биелэлтийн тайлан, үйл ажиллагааны бичмэл тайланг архивлан хадгалсан бөгөөд хагас жилийн үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнүүлээгүй байна.


Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн “Аймгийн Засаг даргын тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” 09 тоот тогтоолын дагуу аймгийн Нийгмийн халамжийн үйлчилгээний хэлтэс, Хөдөлмөрийн хэлтэс нэртэйгээр тус тусдаа үйл ажиллагаа явуулж байсан байгууллагуудыг нэгтгэн 2017 оны 07 дугаар сарын 31-ний өдрөөр аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар болгон өөрчилсөн боловч Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2016 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн Б/21 тоот тушаалаар баталсан бүтэц, орон тооны дагуу 2016 оны 9 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн тус газар Захиргаа хяналтын, Хөдөлмөр эрхлэлтийн, Нийгмийн халамжийн гэсэн 3 хэлтэстэйгээр зохион байгуулагдаж, 24 орон тоотойгоор батлагдсан байна.

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь Халамжийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлийг дэмжих тухай хуулиудын хэрэгжилтийг хангуулах үндсэн чиг үүрэгтэй байгууллага бөгөөд 2016 онд дэвшүүлсэн “Хөдөлмөр

эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай үр дүнтэй шуурхай хүргэх замаар нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн хөдөлмөр, нийгэм халамжийн үйлчилгээний төрийн бодлогыг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх” зорилтын хүрээнд хууль тогтоомжид заасан чиг үүргийнхээ дагуу нийт 4,081 иргэнд халамжийн үйлчилгээг үзүүлсэн байна.

Бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийгдсэнтэй холбоотойгоор тус газрын дарга нь ХХҮЕГ-ын дарга болон аймгийн Засаг даргатай үр дүнгийн гэрээг шинэчилэн байгуулж ажилласан бөгөөд тайлант онд 11 бүлэг, 60 ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажилласнаар ХХҮЕГ-ын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг 84.1 хувь, аймгийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг 94.5 хувьтай тус тус дүгнүүлсэн байна.

Аймгийн ХХҮГ-ын батлагдсан бүтэц, орон тоог схемээр харуулбал:



Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс, Хөдөлмөрийн хэлтсүүд бүтцийн өөрчлөлтөөр нэгдсэнтэй холбоотойгоор бүтэц, орон тоо батлагдах хүртэл 2016 оны 08 дугаар сараас 09 дүгээр сарын 19-нийг хүртэл ажилтнуудын цалинг бууруулалгүй үргэлжлүүлэн олгосон байна.

Тус газар нь шинэчилсэн бүтэц, зохион байгуулалтаар нийт 24 орон тоо батлагдсанаас 2016 оны 09-12 саруудад 21 орон тоотой ажиллаж, 3 орон тоо дутуу ажилласан байна. Тухайлбал: тус газрын дэд дарга томилогдоогүй /аймгийн ХХҮГ-ын дарга нь дэд даргыг ХХҮЕГ-ын даргатай зөвшилцсөний дараа томилдог учраас томилох хугацаа хойшлогдсон/, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтний ажлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн мэргэжилтэнд, няравын ажлыг даргын туслах, архив, бичиг хэргийн ажилтанд түр хугацаагаар тус тус хавсран гүйцэтгүүлсэн байна.

Няравын ажлыг хавсран гүйцэтгүүлэхдээ хавсран ажилласны нэмэгдлийг тооцож олгосон бол Хяналт шинжилгээ, үнэлгээний мэргэжилтний ажлыг

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн мэргэжилтэнд хариуцуулсан боловч цалингийн нэмэгдэл олгоогүй бөгөөд хяналт, шалгалтын ажил хийгдээгүй, ажлын тайлан байхгүй байна.

Тус газар нь үйл ажиллагаагаа ажлын байрны шаардлага хангаагүй, нийтийн орон сууцны орцонд явуулж байсан бөгөөд 2016 онд албан конторын байр шинээр худалдан авч, ажиллагсдын ажиллах орчин нөхцлийг сайжруулснаас гадна үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, иргэдийн үйлчилгээ авах тав тухтай орчин нөхцлийг бүрдүүлсэн байна.

1.2. Бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор төсвийн зардлын төлөвлөлт хийгдээгүй, тооцоо судалгаа байхгүй байна.

Аймгийн НХҮХ нь 2016 оны төсвийн төслийг Төсвийн тухай хуулийн дагуу Сангийн яамны төсвийн бодлого, төлөвлөлтийн газраас гаргасан Төсвийн ерөнхийлөн захирагч нарын “2016 оны төсвийн төсөл, 2017-2018 оны төсвийн төсөөлөл бэлтгэх удирдамж”, НХҮЕГ-аас ирүүлсэн загвар маягтын дагуу бэлтгэн НХҮЕГ-т хуулийн хугацаанд хүргүүлсэн байна. Үүнд:

1. Үйл ажиллагааны зардлын төлөвлөлтийн товчоо маягт № YA3-1,
2. Орон тоо төлөвлөлтийн маягт YA3-2-1,
3. Цалин хөлсний судалгаа төлөвлөлтийн маягт № YA3-2-2,
4. Бараа үйлчилгээний бусад зардлын төсвийн төлөвлөлтийн маягт № YA3-3,
5. Өрх гэрт олгох шилжүүлэг буюу нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлын төлөвлөлтийн маягт №YA3-4

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн 2016 оны төсвийн төсөл болон батлагдсан төсвийн талаарх судалгааг хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөгөөр/

Д/д	Зардлын нэр	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Зөрүү
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	192 575.4	150 194.1	42 381.3
2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21 183.3	16 521.2	4 662.1
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10 285.1	9 865.0	420.1
4	Хангамж бараа материалын зардал	18 498.0	7 167.0	11 331.0
5	Эд хогшил худалдан авах зардал	4 300.0	1 393.8	2 906.2
6	Нормативт зардал	1 200.0		1 200.0
7	Томилолт, зочны зардал	1 250.0	252.7	997.3
8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	4 050.0	3 207.0	843.0
9	Сургалт, хурал, зөвлөгөөний зардал	2 400.0		2 400.0
10	Өрх гэрт олгох шилжүүлэг	1 915.0		1 915.0
Нийт дүн		257 656.8	188 600.8	69 056.0

Хүснэгтээс харахад: 2016 оны төсвийн зардлыг төсвийн саналаас 26.8 хувь буюу 69,056.0 мянган төгрөгөөр бууруулан баталсан байна. Зардлын зүйл ангиар нь авч үзвэл зардал тус бүрийг 4.0-100.0 хувиар бууруулсан байна.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд 2016 оны 07 дугаар сарыг дуусталх хугацаанд 1 дүгээр гарын үсгийг О.Юмжав, 09 дүгээр сараас Д.Гансүх, 2 дугаар гарын үсгийг Б.Аззаяа нар тус тус зурж төсвийг захиран зарцуулж ирсэн байна.

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс нь 2016 оны эхний 7 сарын байдлаар батлагдсан төсвийн дагуу 111,408.0 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авсан байна.

МУ-ын ЗГ-ын тогтоолоор 2016 оны 8 дугаар сард бүтцийн өөрчлөлт хийгдэж аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар болж үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд байгууллагын үйл ажиллагаанд зарцуулах төсвийн тооцоо, судалгааг шинэчлэн гаргаж холбогдох байгууллагад хүргүүлээгүй, ХХҮЕГ-аас 2016 оны 08-12 дугаар сард нийт 165,611.5 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төсвийн хуваарь ирүүлсэн байна. Бүтцийн өөрчлөлттэй холбоотой төсвийн зардлын төлөвлөлт, тооцоо судалгаа хийгдээгүй байна.

Төсвийн хуваарийн дагуу олгох санхүүжилтээс 165,250.6 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, 361.1 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн байна.

ХХҮЕГ-аас ирүүлсэн төсвийн хуваарийн дагуу батлагдсан төсөв болон олгосон санхүүжилтийн судалгааг хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөгөөр/				
Д/д	Зардлын нэр	Батлагдсан төсөв	Авсан санхүүжилт	Зөрүү
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	94 231.9	94 231.9	-
2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9 747.5	9 747.5	-
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5 424.6	5 424.6	-
4	Хангамж бараа материалын зардал	5 389.5	5 389.5	-
5	Нормативт зардал	236.2	236.2	-
6	Эд хогшил худалдан авах зардал	997.2	636.1	361.1
7	Томилолт, зочны зардал	710.8	710.8	-
8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	10.0	10.0	-
9	Бараа үйлчилгээний бусад зардал	661.4	661.4	-
10	Бусад урсгал шилжүүлэг	48 202.6	48 202.6	-
Нийт дүн		165 611.7	165 250.6	361.1

Хүснэгтээс харахад эд хогшил, урсгал засварын зардлын 361.1 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон нь Сангийн яамнаас зарцуулах эрх нээсэн зардлын дүнгээр санхүүжилт олгосонтой холбоотой байна.

1.3. Орон тоо дутуу ажилласнаас бий болсон 4,411.2 мянган төгрөгийн үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлээгүй, төлөвлөгдөөгүй зардалд зарцуулж, төсвийн үр ашгийг бууруулсан байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээний хэлтэс нь 2016 онд 188,600.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас эхний 7 сарын байдлаар нийт 111,408.0 мянган төгрөгийн санхүүжилтийг төсвийн хуваарийн дагуу бүрэн авч, үйл ажиллагааны зардалд 104,953.8 мянган төгрөг зарцуулж 6,454.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн 2016 оны эхний 7 сарын байдлаарх авсан санхүүжилтийг гүйцэтгэлтэй харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөгөөр/

Д/д	Зардлын нэр	Авсан санхүүжилт	Гүйцэтгэл	Зөрүү
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	87 614.1	85 329.8	2 284.3
2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9 636.9	9 549.3	87.6
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6 058.9	5 902.5	156.4
4	Хангамж бараа материалын зардал	3 992.9	3 295.3	697.6
5	Эд хогшил худалдан авах зардал	760.2	130.7	629.5
6	Нормативт зардал	-	-	-
7	Томилолт, зочны зардал	138.0	102.0	36.0
8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	3 207.0	644.1	2 562.9
9	Сургалт, хурал, зөвлөгөөнийн зардал	-	-	-
10	Өрх гэрт олгох шилжүүлэг	-	-	-
Нийт дүн		111 408.0	104 953.7	6 454.3

Хүснэгтээс харахад эхний 7 сарын батлагдсан төсвийг хуваарийн дагуу бүрэн авсан бөгөөд 6,454.3 мянган төгрөгийн төсвийн хэмнэлтийн буцаан төвлөрүүлсэн байна. Тус хэлтсийн нийт зардал 1.0-83.0 хувиар хэмнэгдсэн бөгөөд цалингийн зардал хэмнэгдсэн нь 2 мэргэжилтэн 2 сарын хугацаатай цалингүй чөлөө авсан, харуулын орон тоо сул байсантай холбоотой байна.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газраас Өрхийн мэдээллийн нэгдсэн системийн дахин үнэлгээ, сургалт, баталгаажуулалтын зардалд 3,500.0 мянга, орон нутгийн хөгжлийн сангаас “Хүүхдийн баярын өдөрлөг”-ийн хүрээнд 660.0 мянга, төсвийн урамшуулалд 182.2 мянган төгрөгийг тус тус авч, дээрх үйл ажиллагаанд 3,628.4 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд үлдэгдэл 713.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

МУЗГ-ын тогтоолын дагуу шинээр байгуулагдсан аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт 2016 оны 08-12 сард нийт 165,611.7 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор ХХҮЕГ-аас төсвийн хуваарь ирүүлсэн боловч гүйцэтгэлээр 165,250.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны зардалд 162,770.7 мянган төгрөг зарцуулж 2,479.9 мянган төгрөгийн төсвийн хэмнэлтийг буцаан төвлөрүүлсэн байна.

ХХҮГ-ын 2016 онд авсан санхүүжилтийг зардлын гүйцэтгэлтэй харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөгөөр/

Д/д	Зардлын нэр	Олгосон санхүүжилт	Гүйцэтгэл	Хэм- нэлт
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	94 231.9	94 231.9	-
2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9 747.5	9 747.5	-
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5 424.6	5 424.6	-
4	Хангамж бараа материалын зардал	5 389.5	5 389.5	-
5	Нормативт зардал	236.2	236.2	-
6	Эд хогшил худалдан авах зардал	636.1	559.6	76.5
7	Томилолт, зочны зардал	710.8	710.8	-
8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	10.0		10.0
9	Бараа үйлчилгээний бусад зардал	661.4	661.4	-
10	Бусад урсгал шилжүүлэг	48 202.6	45 809.2	2 393.4

Нийт дүн	165 250.6	162 770.7	2 479.9
----------	-----------	-----------	---------

Хүснэгтээс харахад: 2016 онд нийт санхүүжилтийн 98.5 хувийг үйл ажиллагааны зардалд зарцуулж, төсвийн зардлыг 2,479.9 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Нийт хэмнэсэн зардлын 84.2 хувийг бүтцийн өөрчлөлтөөр ажлаас халагдсан ажилтнуудад олгох тэтгэмжийн зардал эзэлж байна.

Аудитын явцад төсвийн зарцуулалттай холбоотой зарим зардлын анхан шатны баримтын бүрдлийг түүвэрлэн үзэхэд дараах зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

1. Ажилтнуудыг шинээр болон шилжүүлэн томилохоор ХХҮГ-ын даргын тушаал гаргахдаа цалин хөлсний зохицуулалтыг нарийвчлан зааж өгөөгүй, тушаалын огноо зөрүүтэй, утга найруулга тодорхойгүй байна. Тухайлбал: ажилтны цалингийн шатлал, ажилд томилсон тушаал болон цалин шинэчлэн баталсан тушаалуудын огноог зөрүүтэй илэрхийлсэн байна.
2. Тус газар нь батлагдсан орон тооноос 3 орон тоо дутуу ажилласнаас үүссэн 4,411.2 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлээгүй бөгөөд цалингийн сангийн үлдэгдлийг жилийн эцэст албан хаагчдын үр дүнгийн урамшуулалд зарцуулсан,
3. Ахлах нягтлан бодогчид тайлант оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт гараагүй байхад хууль эрхийн үндэслэлгүй тушаалаар 1 сарын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулалд 560.8 мянган төгрөгийг цалингийн сангаас тооцож олгосон,
4. Тэтгэврийн насанд хүрч тэтгэврээ тогтоолгосон ажилтанд хууль эрхийн үндэслэлгүй тушаалаар 1 сарын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг цалингийн зардлаас олгосон,
5. Ажилтнуудын цалингийн шатлалыг тогтоохдоо ажилласан жилийг харгалзан үзээгүйгээс цалингийн шатлалыг ажилласан жилээс зөрүүтэй тогтоож 132.8 мянга, үр дүнгийн гэрээгээр цалингийн шатлалыг ахиулсан боловч үр дүнгийн урамшуулал давхардуулан олгосноос 200.0 мянга, нийт 332.8 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон байна.
6. ХХҮЕГ-аас ирүүлсэн үнэт цаас буюу халамжийн сангийн тэтгэвэр, тэтгэмжийн дэвтэр болон хүнс тэжээлийн эрхийн бичгийг анхан шатны баримтгүй хүлээн авснаас данс бүртгэлд тусгалгүй захиран зарцуулж ирсэн байна.

Дээрх зөрчил дутагдлууд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т “Энэ хуулийн 5.1.1-д заасан төсвийн тогтвортой байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.2.5-д “төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх”, 45 дугаар зүйлийн 45.2-т “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.4-т “төсвийн байгууллага нь батлагдсан орон тооноос дутуу орон тоогоор ажилласнаас бий болсон төсвийн үлдэгдэл”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.5-д “бүх орлого”, 14.4.6-д “Бүх зардал” гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд зориулалт бусаар зарцуулсан 332.8 мянган төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоож, орон тоо дутуу ажиллуулсанаас бий болсон цалингийн зардлын үлдэгдлийг үр дүнгийн болон мөнгөн урамшуулалд олгохгүй байх тухай зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

1.4. Үндсэн хөрөнгийн шинж чанартай 9,619.0 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэж тайлагнасан байна.

Тус газар нь 2016 оны 09 дүгээр сард Хөдөлмөрийн хэлтсээс 26,941.6 мянга, НХҮХ-ээс 8,972.1 мянган төгрөгийн үнэ бүхий бараа материалыг тус тус үнэ төлбөргүй хүлээн авч, орлогоор бүртгэж тайлагнасан бөгөөд тайлант хугацаанд нийт 5,012.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 4,465.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, жилийн эцэст нийт 36,460.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Бараа материалын үлдэгдлийг нэр төрлөөр нь диаграммаар харуулбал:



Диаграммаас харахад: нийт бараа материалын 64.0 хувийг тусгай зориулалтын материал, 26.0 хувийг аж ахуйн материал эзэлж байгаа бөгөөд тусгай зориулалтын материалд дотоод сүлжээний техник, тоног төхөөрөмжийн холбогдолтой бараа материалыг бүртгэж тайлагнасан байна.

Аудитын явцад 2017 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн байдлаарх 141 нэр төрлийн 36,323.7 мянган төгрөгийн бараа материалын дансны үлдэгдлээс 28 нэр төрлийн 21,993.6 мянган төгрөгийн бараа материалд түүвэрчилсэн тооллого хийсэн бөгөөд уг тооллогоор үндсэн хөрөнгийн шинж чанартай 9,619.0 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэж тайлагнасан, мөн байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа үнэт цаасны бүртгэлтэй холбоотой 2,610 ширхэг халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн дэвтрийг данс бүртгэлд тусгаагүй байсан ба хүнсний эрхийн бичгийн үлдэгдэлгүй байна.

ХХҮЕГ-аас үнэт цааснуудыг ирүүлэхдээ анхан шатны баримт үйлдээгүй, хүлээн авсан болон хүлээлгэн өгсөн бүртгэл байхгүйгээс тайлант онд хичнээн үнэт цаас хүлээн авч, зарцуулсан нь тодорхойгүй байна. Тухайлбал: Хүнсний эрхийн бичгийг ХХҮЕГ-аас шуудангаар ирүүлснийг холбогдох мэргэжилтэн хүлээн авч, удирдлагад танилцуулалгүйгээр бүртгэлд тусгалгүй шууд Баянтал, Шивээговь сумдын нийгмийн ажилтанд хүргүүлж, нийгмийн ажилтнууд нь сумдын иргэдэд

олгож ирсэн нь үнэт цаасыг хэрхэн бүртгэх, тайлагнах, зарцуулах талаар шат шатны хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Үнэт цаасны бүртгэлд тавих шат шатны хяналт хангалтгүй байгаа нь аливаа залилан, ашиглал, шамшигдал гарах эрсдлийг бий болгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.5-д “бүх орлого”, 14.4.6-д “Бүх зардал”, 19 дүгээр зүйлийн 19.1-т “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно”, НХҮЕГ-ын даргын 2014 оны 13 дугаар тушаалаар батлагдсан “Нийгмийн халамж, үйлчилгээний байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийн 3 дугаар бүлгийн 3.1.4-т “Бараа материалын бүртгэлийн тусгай бодлого хэсэгт Нийгмийн халамж үйлчилгээний дээд шатны байгууллагаас ирсэн дэвтэр, маягтыг орлого авах, зарлага болгох” гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд үндсэн хөрөнгийн шинж чанартай 9,619.0 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд шилжүүлэн бүртгэх, НБББББ-ийг мөрдөж ажиллах, үнэт цаасны орлого, зарлагын зарцуулалтад тавих шат шатны хяналтыг сайжруулж, бүртгэлийг бүрэн хөтөлж хэвших, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

1.5. Ашиглах боломжгүй болсон 30,000.0 мянган төгрөгийн зураг төсвийн үнэ нийт үндсэн хөрөнгийн 14.0 хувийг эзэлж байна.

Аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэст 2016 оны эхний 7 сарын байдлаар нийт 36,598.7 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 32,359.5 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хассан байна.

2016 оны 8 дугаар сараас хийгдсэн бүтцийн өөрчлөлтөөр аймгийн Хөдөлмөрийн хэлтэстэй нэгтгэж Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар болж өөрчлөгдсөн бөгөөд тус газар нь 2016 оны жилийн эцсийн байдлаар 36,460.2 мянган төгрөгийн бараа материал, 218,709.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэж тайлагнасан байна.

Аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт ХХҮЕГ-ын 2016 оны 09 сарын 26-ны өдрийн 8/122 тоот албан бичгээр “Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс болон Хөдөлмөрийн хэлтсүүдийн үндсэн болон эргэлтийн хөрөнгийг ангилал тус бүрээр гарган тухайн аймаг, дүүргийн төрийн өмчийн болон орон нутгийн зохих шатны байгууллагатай хамтран тооллогыг баталгаажуулан тулгах тухай” чиглэл ирүүлсний дагуу Орон нутгийн өмчийн албаны мэргэжилтэнтэй хамтран 2016 оны 09 сарын 28-ны өдөр тооллого хийж, нийт 268 нэр төрлийн 1,775 ширхэг, 439,823.0 мянган төгрөгийн хөрөнгийг тоолсон байна.

Тооллогоор Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн 77 нэр төрлийн 182 ширхэг 205,762.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 96 нэр төрлийн 295 ширхэг 16,688.4 мянга төгрөгийн эргэлтийн хөрөнгө, Хөдөлмөрийн хэлтсийн 57 нэр төрлийн 182 ширхэг 190,430.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 38 нэр төрлийн 1,116 ширхэг 26,941.6 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгө тус тус тоологдсон байна.

Аймгийн ХХҮГ-ын даргын 2016 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/28 дугаар тушаалаар эд хөрөнгийн тооллого хийх ажлын хэсэг байгуулан 2016 оны 12 дугаар сарын 20-23-ны өдрүүдэд эд хөрөнгийн тооллого хийж, тооллогын комиссын тайлан, тооллого хийсэн жагсаалтыг архивласан байна. Жилийн эцсийн тооллогоор ажилтан тус бүрийн ашиглаж буй эд хөрөнгийг тухайн эд хариуцагчид хариуцуулан картжуулсан байна.

2016 оны 07 дугаар сарын 31-ний өдрөөс аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулсан боловч Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2016 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 8/470 дугаартай албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу хаалтын болон эхлэлтийн санхүүгийн тайланг 2016 оны 12 дугаар сарын 12-нд гаргасан байна. 2016 оны 12 дугаар сард хаалтын тайланг бэлтгэхдээ 11 дүгээр сарын 30-ныг дуусталх хугацааны үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцсон байна.

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт тайлант онд нийт 218,710.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна. Үүнд: АИТХ-ын 2016 оны 12 сарын 5-ны өдрийн тогтоолоор НХҮХ-ийн 96,179.5 мянга, Хөдөлмөрийн хэлтсийн 122,530.8 мянга, нийт 218,710.3 мянган төгрөгийн үнэтэй, 103,931.8 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй үндсэн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн авч хөрөнгийн орлогоор бүртгэж тайлагнасан бөгөөд тайлант хугацаанд нийт 1,214.6 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцогдсон байна.

2016 оны жилийн эцсийн байдлаарх үндсэн хөрөнгийн үнэлгээг нэр төрлөөр нь харуулбал:



Диаграмаас харахад: тайлан тэнцэлд тусгагдсан үндсэн хөрөнгөд програм хангамж 1.0 хувь, бусад хөрөнгө 14.0 хувь, тавилга, эд хогшил болон тээврийн хэрэгсэл тул тус 18.0 хувь, машин, тоног төхөөрөмж 49.0 хувийг эзэлж байна.

Бусад үндсэн хөрөнгө 14.0 хувийг эзэлж байгаа нь шинээр барилга барихаар зураг төсвийг 30,000.0 мянган төгрөгөөр хийлгэсэн боловч 2016 оны 12 дугаар сард шинээр баригдсан албан конторын барилга худалдаж авснаар тухайн зураг төсвийг ашиглах боломжгүй болсон байна.

Иймд уг зураг төсвийг ашиглах боломжтой газарт шилжүүлэн өгөх талаар холбогдох байгууллагад санал хүргүүлэх нь зүйтэй юм.

Аудитын явцад нийт 218,703.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөд тооллого хийсэн бөгөөд ажилтан тус бүрт ашиглаж буй хөрөнгийг картжуулан хариуцуулсан байна.



Тооллогын явцад агуулахад хадгалагдаж буй 17 нэр төрлийн 9,500.4 мянган төгрөгийн хөрөнгөөс 7 нэр төрлийн 6,951.8 мянган төгрөгийн хөрөнгө нь эвдэрсэн, бодитоор оршин байгаагүй 1,309.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг ХХААГ-ын ЖДҮ хариуцсан мэргэжилтэнд ашиглуулж байна.

Энэ нь 2015 онд аймгийн Хөдөлмөрийн хэлтэст харъяалагдаж байсан ЖДҮ хариуцсан мэргэжилтэнг аймгийн ХХААГ-т шилжүүлэхдээ ашиглаж байсан тоног төхөөрөмжийг хамт шилжүүлэх тухай чиглэл ирүүлсэн боловч Төрийн өмчийн хорооноос тухайн мэргэжилтний хөрөнгийг шилжүүлэх шийдвэр ирээгүй, одоог хүртэл өөр байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байна.

2016 оны жилийн эцсийн байдлаар нийт үндсэн хөрөнгийн 6.0 хувь буюу 13,292.4 мянган төгрөгийн анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн хөрөнгө ашиглагдаж байгаа бөгөөд ашиглалтын хугацаа дууссан, дансны үнэ нь тэг өртөгтэй хөрөнгүүдийг цэгцлэх талаар тодорхой ажил зохион байгуулж ажиллаагүй байна.

Энэ нь МУ-ын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-т “Хэмжигдэхүйц”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгүүдийг данснаас хасах, эсхүл цаашид ашиглах боломжтой гэж үзсэн тохиолдолд хөрөнгийн ашиглах хугацаа, үнэлгээг тогтоох, эвдэрсэн хөрөнгийг засварлах боломжгүй бол холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрээр данснаас хасах, ХХААГ-т ашиглагдаж байгаа хөрөнгийн болон зураг төсвийн асуудлыг шийдвэрлүүлэх тухай зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

1.6. Байгууллагын үндсэн чиг үүргийн хэрэгжилт, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

НХҮХ нь НХҮЕГ-аас батлагдсан орон тоо, бүтцийн дагуу Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтнийг томилон ажиллуулсан бөгөөд тусдаа дотоод хяналтын нэгж байгуулаагүй байна.

Уг мэргэжилтэн нь 2016 онд хийх ажлын төлөвлөгөөг хагас, бүтэн жилээр боловсруулан НХҮХ-ийн Захиргаа, хяналтын албаны даргаар батлуулан ажиллаж ирсэн байна.

Эхний хагас жилд хийгдсэн хяналт шалгалтаар архив, албан хэрэг хөтлөлтийн стандартын хэрэгжилтийн байдалд хийсэн хяналт шалгалтыг албаны даргын баталсан удирдамжийн дагуу хийсэн бөгөөд шалгалтаар илэрсэн, дутагдлыг арилгуулж, холбогдох ажилтанд зөвлөмж өгч, биелэлтийг хангуулан ажилласан боловч хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой хяналт шалгалтын ажил хийгдээгүй байна.

МУЗГ-ын тогтоолоор бүтцийн өөрчлөлт хийгдэж ХХҮГ болсноор хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод ажил хариуцсан ажилтны орон тоонд хүн томилогдоогүй бөгөөд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн мэргэжилтэнд давхар хариуцуулсан боловч сүүлийн хагас жилд хяналт шалгалтын ажил хийгдээгүй, ажлын төлөвлөгөө, тайлан байхгүй байна.

Тус газрын удирдлагын зүгээс санхүүгийн үйл ажиллагаанд тавих анхан шатны хяналт хангалтгүй байна. Тухайлбал: Хууль эрхийн үндэслэлгүй тушаалаар мөнгөн урамшуулал олгох, Халамжийн сангийн үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн дэвтрийг данс бүртгэлд тусгаагүй, мэргэжилтнүүдэд олгохдоо дэвтрийн шифр болон тоо ширхгээр нь бүртгэлжүүлээгүй зэрэг зөрчил дутагдал илэрсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэснийг зөрчсөн байна.

2016 онд аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний тасгаас НХҮХ-ийн эхний хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шижнилгээ үнэлгээ хийгдсэн бөгөөд бусад байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

1.7. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т “...дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна”, 3.1.5-д “төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч” гэсэн заалтын үйлчлэх хүрээнд аймгийн ХХҮГ хамаарч байна.

Аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн шилэн дансны цэсэнд 2016 оны 01-08 дугаар сарын мэдээллүүдийг байршуулсан бөгөөд нийт 88 мэдээлэл байршуулснаас 44.3 хувь буюу 39 мэдээлэл нь хугацаа хоцорсон байна.

МУЗГ-ын тогтоолоор бүтцийн өөрчлөлт хийгдсэнээр шилэн дансны цэсийг шинээр нээлгэн 2016 оны 08-12 дугаар сард нийт 67 мэдээлэл байршуулснаас 61.1 хувь буюу 41 мэдээлэл хоцорсон төлөвтэй байна.

Энэ нь ХХҮЕГ-аас нэгдсэн журмаар Сангийн яаманд хүсэлт гаргасны дагуу цэс нь нээгдсэн бөгөөд 10 дугаар сард мэдээлэл байршуулах буюу нэвтрэх эрх нь нээгдсэнээс шалтгаалсан байна.

Иймд Шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн оруулж хэвших шаардлагатай бөгөөд мэдээллийг олон удаа хугацаа хоцроож, дутуу мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т “Шилэн дансны тухай хууль тогтоомж зөрчсөн төсвийн байгууллагын албан тушаалтанд зөрчлийн шинж байдлыг харгалзан түүнийг томилсон эрх бүхий этгээд Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан сахилгын шийтгэл ногдуулна” гэсний дагуу хариуцлага тооцуулах үндэслэл болохыг анхаарч ажиллахыг зөвлөж байна.

**Говьсүмбэр аймгийн Халамжийн сангийн
төлөвлөлт, зарцуулалт үр дүнтэй эсэх**

Бүлэг 2

**Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэдийн
судалгааг бүрэн гаргаж, холбогдох байгууллагуудтай
ажлын уялдаа, холбоогоо сайжруулах шаардлагатай
байна.**

2.1 Халамжийн сангийн төсвийг үндэслэлтэй төлөвлөж, батлуулаагүй байна.

Аймгийн Халамжийн сангийн 2016 оны төсвийн төслийг боловсруулахдаа дараах хууль эрхийн актуудыг баримталсан байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1-д “төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаг төсвийн шууд захирагч нь жилийн төсвийн төслөө жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор харьяалах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэх”

- 2012 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн төсвийн хөрөнгийн суурь зарлагыг тооцох аргачлал",
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам",
- МУЗГ болон холбогдох яамд, НХҮЕГ, ХХҮЕГ-аас хамгийн сүүлд тогтоосон тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж үйлчилгээний нэр төрөл, хэмжээ,

Халамжийн сангийн төсвийн төлөвлөлтөд дээрх хууль эрхийн актуудыг баримтлахаас гадна нийгмийн халамж, үйлчилгээний мэдээллийн нэгдсэн систем, өмнөх оны зардлын гүйцэтгэл болон халамжийн үйлчилгээнд хамрагдаж буй иргэдийн судалгаа, мэдээлэлд үндэслэн холбогдох тайлан мэдээ судалгааг ашиглан зардлын нэр төрөл тус бүрээр тооцсон байна.

2016 оны аймгийн Халамжийн сангийн зардлыг нийт 1,609,254.0 мянган төгрөгөөр тооцож, төсвийн төслийг боловсруулан НХҮЕГ болон аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст тус тус хүргүүлсэн боловч төлөвлөсөн зардлын дүнг 53,109.2 мянган төгрөгөөр бууруулан 1,556,144.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Батлагдсан төсвийн 12.1 хувь буюу 188,500.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 87.9 хувь буюу 1,367,644.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс тус тус санхүүжүүлэхээр баталсан байна.

Тайлант онд орон нутгийн төсвийн тодотголоор халамжийн сангийн зардлыг анх батлагдсан төлөвлөгөөнөөс 13,714.8 мянган төгрөгөөр бууруулан 1,542,430.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Халамжийн сангийн 2015-2016 оны төсвийн төсөл болон батлагдсан төсвийг харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

		2015			2016		
Д/д	Зардлын нэр	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Зөрүү	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Зөрүү
Улсын төсвийн санхүүжилт							
1	Алдар цолтой ахмад настанд үзүүлэх тэтгэмж	21 200.0	31 000.0	-9 800.0	28 766.0	22 500.0	6 266.0
2	Алдарт эхийн одонгийн тэтгэмж	159 300.0	171 000.0	-11 700.0	176 500.0	166 000.0	10 500.0
Нийт улсын төсвийн дүн		180 500.0	202 000.0	-21 500.0	205 266.0	188 500.0	16 766.0
Орон нутгийн төсвийн санхүүжилт							
1	Халамжийн тэтгэвэр	469 200.0	471 482.0	-2 282.0	483 483.0	485 760.0	-2 277.0
2	Жирэмсэн хөхүүл эхийн тэтгэмж	366 720.0	274 196.0	92 524.0	254 400.0	288 000.0	-33 600.0
3	Нөхцөлт мөнгөн тэтгэмж	148 896.0	322 248.0	-173 352.0	252 942.0	216 456.0	36 486.0
4	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн хал/үйл	36 600.0	15 495.0	21 105.0	40 074.0	8 000.0	32 074.0
5	Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж	115 660.0	-	115 660.0	103 560.0	121 352.0	-17 792.0
6	ХБИ-д үзүүлэх нийгмийн хал/үйлчилгээ	57 140.0	87 299.0	-30 159.0	77 560.0	77 560.0	-
7	Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт	93 807.0	122 798.0	-28 991.0	117 170.0	93 807.0	23 363.0
8	Хоол тэжээлийн тусламж дэмжлэг	48 060.0	65 380.0	-17 320.0	62 088.0	51 995.0	10 093.0
9	Зөвлөл, комиссын гишүүдийн ажлын хөлс	8 100.0	5 894.0	2 206.0	6 307.0	5 400.0	908.0
10	Сургалт семинар зохион байгуулах зардал	-	11 821.0	-11 821.0	2 708.0	1 282.0	1 427.0
11	Банк санхүүгийн үйл/ хураамж	3 300.0	1 900.0	1 400.0	1 375.0	3 200.0	-1 825.0

12	Мэдээлэл сурталчилгааны зардал	-	-	-	2 319.0	1 118.0	1 201.0
Орон нутгийн нийт дүн		1 347 483.0	1 378 513	-31 030.0	1 403 987.0	1 353 930.0	50 057.0
Халамжийн сангийн нийт дүн		1 527 983.0	1 580 513	-52 530.0	1 609 254.0	1 542 430.0	66 824.0

Дээрх хүснэгтээс харахад: 2015 оны батлагдсан төсвийг төсвийн төслийн дүнгээс 3.4 хувь буюу 52,530.0 мянган төгрөгөөр илүү баталсан бол 2016 оны батлагдсан төсвийг төсвийн төслөөс 4.1 хувь буюу 66,824.0 мянган төгрөгөөр бууруулан баталсан байна.

Халамжийн сангийн 2016 оны батлагдсан төсвийг өмнөх онтой харьцуулахад нийт дүнгээрээ улсын төсвөөс олгох санхүүжилт 13,500.0 мянга, орон нутгийн төсвөөс олгох санхүүжилт 24,583.0 мянга, нийт 38,083.0 мянган төгрөгөөр буурсан байна.

2016 оны халамжийн сангийн батлагдсан төсвийг зардлын зүйл ангиар өмнөх оны батлагдсан төсөвтэй харьцуулж үзэхэд:

- халамжийн тэтгэвэр 3.0 хувь,
- жирэмсэн болон хөхүүл эхийн тэтгэмж 5.0 хувь,
- амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж 100.0 хувиар тус тус нэмэгдүүлсэн,
- алдарт эхийн одонгийн тэтгэмж 3.0 хувь,
- алдар цолтой ахмад настанд үзүүлэх тэтгэмж 27.0 хувь,
- ХБИ-д үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээний зардал 11.0 хувь,
- хоол тэжээлийн тусламж дэмжлэгийн зардал 20.0 хувь,
- ахмад настуудад үзүүлэх хөнгөлөлтийн зардал 24.0 хувь,
- нөхцөлт мөнгөн тэтгэмж 33.0 хувь,
- олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг 48.0 хувиар тус тус бууруулж баталсан үзүүлэлттэй байна.

Халамжийн сангийн зардлыг төлөвлөхдөө иргэдийн тоонд үндэслэн төлөвлөж хүргүүлдэг боловч батлагдсан төсвийн хуваарьт халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэдийн тоог тодорхой ирүүлээгүй байна.

Халамжийн сангийн үйл ажиллагааны зардалд зарцуулагдах зөвлөл, комиссын гишүүдийн ажлын хөлс болон сургалт семинар зохион байгуулах зардлууд 8.0-89.0 хувиар бууруулсан бол банк санхүүгийн үйлчилгээний хураамж, мэдээлэл сурталчилгааны зардлуудыг 68.0-100.0 хувиар нэмэгдүүлэн баталсан байна.

2015, 2016 оны Халамжийн сангийн төсөвт халамжийн үйлчилгээ болон тус сангийн үйл ажиллагааны зардлын эзлэх хувийг диаграмаар харуулбал:



Диаграмаас харахад 2015, 2016 оны Халамжийн сангийн нийт батлагдсан төсвийн 99.0 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж үйлчилгээний зардалд, 1.0 хувь нь сангийн үйл ажиллагааны зардалд зарцуулахаар батлагдсан байна.

2.2 Нийгмийн халамжийн үйлчилгээнд хуулиар тодорхойлсон иргэдийг бүрэн хамруулахад шаардлагатай судалгаа, шинжилгээний ажил хийгдээгүй байна.

Халамжийн сангаас дараах хууль эрхийн хүрээнд халамжийн үйлчилгээг үзүүлж байна. Үүнд:


- Нийгмийн халамжийн тухай хууль
- Ахмад настны нийгмийн хамгааллын тухай
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай
- Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай
- Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавъяат цолтон ахмад настанд төрөөс олгох нэмэгдлийн тухай
- Хүний хөгжил сангийн тухай хууль

Эдгээр хуулиудын хүрээнд Халамжийн сангаас нийт 94 төрлийн халамжийн үйлчилгээ үзүүлэхээс 2016 онд 54 төрлийн халамжийн үйлчилгээ үзүүлж, давхардсан тоогоор 4,060 иргэн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд хамрагдсан байна.

Нийгмийн халамж, үйлчилгээний мэдээллийн нэгдсэн системийн бүртгэл тайлангаар 2016 онд халамжийн үйлчилгээнд нийт 4,060 иргэн хамрагдсан нь өмнөх онтой харьцуулахад 575 иргэнээр буурсан байна. Энэ нь 2015 онд ахмад настанд хүндэтгэл үзүүлэх үйлчилгээг жилд 2 удаа зохион байгуулдаг бөгөөд өмнөх онд хүндэтгэл үзүүлсэн ахмадын тоог давхардуулан тооцсонтой холбоотой байна.

2015-2016 онд халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоог, зардлын нэр төрлөөр харьцуулсан судалгааг графикаар харуулбал:

Халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тооны өсөлт, бууралт /зардлын ангилал тус бүрээр/



Графикаас харахад Алдар цолтой ахмад настанд үзүүлэх тэтгэмж, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, жирэмсэн болон хөхүүл эхийн тэтгэмж, Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо өмнөх оноос 2-587-гоор буурсан үзүүлэлттэй бол бусад үйлчилгээ нь 1-110-аар нэмэгдсэн байна.

Энэ нь Алдар цолтой ахмад настанд үзүүлэх тэтгэмж, жирэмсэн болон хөхүүл эхийн тэтгэмжид хамрагдсан иргэдийн тоо буурсан үзүүлэлттэй байгаа нь халамжийн мөнгөө сар бүр авалгүй, он дамжуулж авч байгаагаас шалтгаалсан бол Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлтийн үйлчилгээ нь рашаан сувилал болон амралтын газарт амрах иргэд цөөрсөн, иргэдийн амжиргааны түвшин буурсан, мөн өмнөх онд халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоог давхардуулан тооцсонтой холбоотой байна.

Аймгийн ХХҮГ-аас Нийгмийн халамжийн үйлчилгээнд хуулиар тодорхойлсон иргэдийг бүрэн хамруулах талаар хийсэн судалгаа, шинжилгээ дутагдалтай байна. Тухайлбал: 2016 онд Сүмбэр суманд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 57 өрх хамрагдаж, хүнсний эрхийн бичиг авсан байна. Эдгээр иргэдийн мэдээллийг тус сумын 6-р багийн нийгмийн ажилтнаас гаргуулан авсан ядуу болон нэн ядуу гэсэн ангилалд хамааралтай 226 өрхийн 962 иргэний судалгаатай тулган баталгаажуулахад 22 өрхийн иргэд хамрагдсан нь нийт өрхийн 9.7 хувийг эзэлж байна.

Энэ нь нийгмийн ажилтны судалгаанд хамрагдсан болон халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо хэт зөрүүтэй байгаа нь хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ 2013 онд хийгдсэн судалгааны үр дүнгээр олгогдсон, мөн нутгийн засаг захиргааны байгууллагын анхан шатны нэгж болох багийн Засаг дарга, нийгмийн ажилтнуудтай уялдаа холбоотой ажиллаагүйгээс халамжийн үйлчилгээ авах шаардлагатай иргэд бүрэн хамрагдаагүй байх магадлалтай байна.

Халамжийн үйлчилгээг үзүүлэхэд зарим хууль эрхийн актууд хоорондоо зөрчилдөж байна. Тухайлбал: ЗГ-ын 2012 оны 185 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Ахмад настанд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам”-аар зохицуулагдаж байсан ХБИ болон ахмад настанд олгодог протез, ортопед зэрэг нэмэлт болон тусгай хэрэгслийн хөнгөлөлтийг ЗГ-ын 2014 оны 343 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд уг өөрчлөлтөөр “Ахмад настанд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.6-д “Ахмад настан энэхүү журмын 1.2-т заасан протезийн хэрэгслийг өөрийн сонгосон байгууллагаас авна” гэж заасан боловч уг журмын 1.7-д “Энэ журмын 1.2-т заасан ортопед болон тусгай хэрэгслийг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн асуудал хариуцсан байгууллагатай гэрээ байгуулсан байгууллагуудаас ахмад настан өөрөө сонгож авна” гэж өөрчилсөн байна. Энэ нь заавал аймгийн ХХҮГ-тай гэрээ байгуулсан газраас үйлчилгээ авахаар заасан бөгөөд иргэдийн хувьд өөрийн сонголтоор дээрх үйлчилгээг авах боломжгүй байна.

Цаашид халамжийн үйлчилгээнд хуулиар тодорхойлсон иргэдийг бүрэн хамруулахын тулд сумын болон багийн Засаг дарга, нийгмийн ажилтнуудтай хамтран ажиллах, хууль тогтоомж, холбогдох журмуудыг сурталчилах ажлыг сайжруулах шаардлагатай байна.

2.3. Халамжийн сангийн төсвийн зарцуулалт жил бүр 75.9-81.8 хувьтай байгаа нь зорилтот бүлгийн иргэдийг бүрэн хамруулаагүй, төсвийг үндэслэлтэй төлөвлөж, батлуулаагүйтэй холбоотой байна.

Аймгийн Халамжийн сангийн зардалд 2016 онд 1,531,430.0 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 1,261,348.0 мянган төгрөг зарцуулагдсан бөгөөд үүнээс халамжийн үйлчилгээнд 1,255,755.0 мянга, сангийн үйл ажиллагааны зардалд 5,593.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж, төсөв 281,082.0 мянган төгрөгийн хэмнэлттэй байна.

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээс Алдарт эхийн одонгийн тэтгэмж 1,197 иргэнд 163,480.0 мянга, Алдар цолтой ахмад настанд үзүүлэх тэтгэмжийг 7 иргэнд 12,966.0 мянга, орон нутгийн төсвөөс нийт 2,856 иргэнд 1,079,309.0 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж олгосон байна.

Халамжийн сангийн төсвийн зарцуулалтыг өмнөх онтой харьцуулсан судалгааг нэр төрлөөр нь хүснэгтээр харуулбал:

							/мянган төгрөгөөр/	
Д/д	Зардлын нэр	2016			2015			
		Төсөв	Гүйцэт-гэл	Зөрүү	Төсөв	Гүйцэт-гэл	Зөрүү	
Улсын төсвийн санхүүжилт, зарцуулалт								
1	Алдар цолтой ахмад настанд үзүүлэх тэтгэмж	22 500.0	12 966.0	9 534.0	31 000.0	19 545.0	11 456.0	
2	Алдарт эхийн одонгийн тэтгэмж	166 000.0	163 480.0	2 520.0	171 000.0	161 820.0	9 180.0	

Нийт улсын төсвийн дүн		188 500.0	176 446.0	12 054.0	202 000.0	181 365.0	20 636.0
Орон нутгийн төсвийн санхүүжилт, зарцуулалт							
1	Халамжийн тэтгэвэр	485 760.0	389 170.0	96 590.0	471 482.0	377 613.0	93 869.0
2	Жирэмсэн хөхүүл эхийн тэтгэмж	288 000.0	211 447.0	76 553.0	274 196.0	201 942.0	72 254.0
3	Нөхцөлт мөнгөн тэтгэмж	216 456.0	160 012.0	56 444.0	322 248.0	249 477.0	72 772.0
4	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн хал/үйл	8 000.0	5 060.0	2 940.0	15 495.0	11 806.0	3 690.0
5	Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж	121 352.0	126 822.0	- 5 470.0			0
6	ХБИ-д үзүүлэх нийгмийн хал/ үйлчилгээ	77 560.0	70 155.0	7 405.0	87 299.0	51 764.0	35 535.0
7	Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт	93 807.0	76 099.0	17 708.0	122 798.0	79 677.0	43 121.0
8	Хоол тэжээлийн тусламж дэмжлэг	51 995.0	40 545.0	11 450.0	65 380.0	39 143.0	26 237.0
9	Зөвлөл, комиссын гишүүдийн ажлын хөлс	5 400.0	3 982.0	1 418.0	5 894.0	4 397.0	1 497.0
10	Сургалт семинар зохион байгуулах зардал	1 282.0	799.0	482.0	11 821.0	1 804.0	10 017.0
11	Банк санхүүгийн үйл/ хураамж	3 200.0	812.0	2 388.0	1 900.0	790.0	1 110.0
12	Мэдээлэл сурталчилгааны зардал	1 118.0		1 118.0			0
Орон нутгийн нийт дүн		1 353 930.0	1 084 902.0	269 028.0	1 378 513.0	1 018 411.0	360 103.0
Халамжийн сангийн нийт дүн		1 542 430.0	1 261 348.0	281 082.0	1 580 513.0	1 199 775.0	380 738.0

Хүснэгтээс харахад: 2016 онд Халамжийн сангийн зарцуулалт өмнөх оноос 6.5 хувиар нэмэгдсэн байна. Батлагдсан төсвийг 2016 онд 75.9 хувь буюу 281,082.0 мянга, 2015 онд 81.8 хувь буюу 380,738.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна. Төсвийн хэмнэлт нь төсвийг үндэслэлтэй төлөвлөж, батлуулаагүйтэй холбоотой байна.


2016 онд батлагдсан зардлыг нэр төрөл тус бүрээр 2,520.0-96,590.0 мянган төгрөгөөр хэмнэсэн бөгөөд шалтгааныг тодруулбал:

- Алдар цолтой ахмад настанд үзүүлэх тэтгэмж 9,534.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь төсвийн төслийг үндэслэлгүй төлөвлөсөн
- Алдарт эхийн одонгийн тэтгэмж 2,520.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь мөн төсвийн төслийг өмнөх онуудын гүйцэтгэлд үндэслэн төлөвлөсөн боловч алдарт эхийн одонгоо хугацаанд нь аваагүй
- Халамжийн тэтгэврийн 96,590.0 мянган төгрөгийн хэмнэлт нь ажилласан жилийн нөхөн тооцолтоор Нийгмийн даатгалын хэлтсээс тэтгэвэр авах эрх үүссэн иргэд шилжсэн
- Жирэмсэн хөхүүл эхийн тэтгэмж 76,553.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь төсвийн төслийг 33,600.0 мянган төгрөгөөр үндэслэлгүй нэмэгдүүлж батлуулсан, мөн өмнөх оноос жирэмслэлт, төрөлт буурсантай холбоотой
- Нөхцөлт мөнгөн тэтгэмжийн хэмнэлт нь төсвийн төслийг үндэслэлгүй төлөвлөсөн
- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хувьд НХҮЕГ-т тендер зарлаж дээрх үйлчилгээ явуулах байгууллагыг шалгаруулан магадлан итгэмжлэгдсэн ААНБ-д зөвшөөрөл олгож гэрээ байгуулдаг бөгөөд 2016 онд Говьсүмбэр аймагт дээрх үйлчилгээ явуулах зөвшөөрөлтэй магадлан итгэмжлэгдсэн байгуулага байгаагүйгээс тухайн үйлчилгээнд зарцуулагдаагүй
- Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламжийн зардал 5,470.0 мянган төгрөгөөр хэтэрсэн нь 16 хүртлэх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгодог тэтгэмжийн мөнгөн дүн нэмэгдсэнтэй холбоотой

- ХБИ-д үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээний зардлын хэмнэлт нь сонсголын аппаратын хөнгөлөлтөөр иргэдэд үйлчилгээ үзүүлээгүйтэй холбоотой
- Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлтийн зардлын хэмнэлт нь 2016 онд сонсголын аппаратын хөнгөлөлтөөр иргэдэд үйлчилгээ үзүүлээгүй, мөн ахмадын амралт сувиллын үйлчилгээнд хамрагдах иргэдийн тоо буурсантай холбоотой
- Хоол тэжээлийн тусламж дэмжлэгийн зардал нь улсын хэмжээнд өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаа явуулах тухай чиглэл ирсний дагуу иргэдийг шинээр судалгаанд хамруулаагүйтэй холбоотой
- Зөвлөл, комиссын гишүүдийн ажлын хөлсний зардал нь нийгмийн халамжийн тухай хуулийн 8.2.6-д зааснаар сумдын Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдэд хуралдааны ирцээс хамаарч урамшуулал тооцож олгосны дагуу зарцуулагдаагүй үлдэгдлийг төвлөрүүлсэн
- Сургалт семинар зохион байгуулах болон мэдээлэл сурталчилгааны зардлын хэмнэлт нь бүтэц, орон тоо өөрчлөгдсөнтэй холбоотойгоор сургалт зохион байгуулагдаагүй
- Банк санхүүгийн үйлчилгээний хураамжийн хэмнэлт нь ХХҮЕГ-аас байгуулсан арилжааны төв банкуудтай хамтран ажиллах гэрээний дагуу үйлчилгээний шимтгэлийг 1 удаагийн олголт 50 төгрөгөөр тооцон шилжүүлсэн бөгөөд зардлыг өндөр төлөвлөж батлуулсантай холбоотой байна.

2016 оны жилийн эцэст нийт батлагдсан төсвийн 18.2 хувь буюу 281,082.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн бөгөөд үүнээс улсын төсөвт 12,054.0 мянга, орон нутгийн төсөвт 269,028.0 мянган төгрөгийг тус тус шилжүүлсэн байна.

Аймгийн Халамжийн сангийн зарцуулалтын эзлэх хувийг диаграммаар харуулбал:



Диаграмаас харахад: Халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжүүд 1-31 хувийг эзэлж байгаа бол үйл ажиллагааны зардал нь нийт төсвийн 1.0 хувийг эзэлж байна.

Халамжийн сангийн тэтгэвэр, тэтгэмжийг Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан иргэнд сар бүр, уг хуулийн 13 дугаар зүйлд заасан нийгмийн халамжийн тэтгэмжийг 13.2, 13.3, 13.5, 13.6, 13.7, 13.7-д заасан иргэдэд холбогдох журмуудад заасны дагуу олгох бөгөөд шаардлагатай баримт материалыг бүрэн бүрдүүлсэн иргэний мэдээлэл, хувийн хэрэг материалыг тус газрын мэргэжилтэн хүлээн авч, ахлах мэргэжилтэн болон хэлстийн даргаар хянуулсны дараа газрын даргын зөвшөөрлөөр арилжааны банкаар дамжуулан олгож байна.

Тухайлбал жилд 1 удаа буюу сар бүр тэтгэвэр тэтгэмж олгож байгаа иргэнд хувийн хэрэг нээж, арилжааны банкаар дамжуулан олгож байгаа бөгөөд хүнсний эрхийн бичгийг Сүмбэр суманд цахимаар буюу арилжааны банкинд нээлгэсэн тусгай картаар олгодог бол Баянтал, Шивээговь сумдад үнэт цаасаар сумдын Нийгмийн ажилтан олгож байна. Мөн амралт, рашаан сувилалын хөнгөлөлтийг тухайн амралт, сувиллын газарт амарч ирсний дараа тухайн амралтын газарт амарч сувилуулсан болон төлбөр төлсөн баримт, эмчийн тодорхойлолт, багийн засаг даргын тодорхойлолт зэрэг журамд заагдсан баримт материалуудыг бүрэн бүрдүүлсний дараа арилжааны банкаар дамжуулан олгож байна.

Аудитын явцад Халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой дараах зөрчил дутагдлууд илэрлээ. Үүнд:

- Баянтал сумын хүнсний эрхийн бичгийн олголтын анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна. Тухайлбал: Баянтал сумын мэргэжилтэн хүнсний эрхийн бичиг олгохдоо тухайн хүлээн авсан иргэдээр гарын үсэг зуруулаагүй, тухайн иргэн уг эрхийн бичгийг хүлээн авсан эсэхийг нотлох баримтгүй байна.
- Шивээговь суманд хүнсний эрхийн бичиг авах эрх үүссэн иргэдэд эрхийн бичиг олгосон баримт бичгийг сери дугаартай нь бүртгэн баримтжуулсан, гэрээт дэлгүүрээс хүнсний бүтээгдэхүүн хүлээн авсан анхан шатны баримтуудыг бүрэн бүрдүүлсэн боловч “Шивээ сервис” ХХК-тай байгуулсан гэрээний үүргээ зөрчиж, 2016 оны 1-2 дугаар сарын санхүүжилт 897.0 мянган төгрөгийг гэрээт дэлгүүрт олгоогүй, тайлан тэнцэлд өглөгөөр бүртгэж тайлагнаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.3-т “бүх өр төлбөр”, 14.4.5-д “бүх орлого”, 14.4.6-д “Бүх зардал”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд дээрх зөрчлийг арилгуулах тухай албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

2.4 Халамжийн сангийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс нь НХҮЕГ-аас батлагдсан орон тоо, бүтцийн дагуу Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтнийг томилон ажиллуулсан бөгөөд уг мэргэжилтэн нь 2016 онд хийх ажлын төлөвлөгөөг хагас, бүтэн жилээр боловсруулан НХҮХ-ийн Захиргаа, хяналтын албаны даргаар батлуулан ажиллаж ирсэн байна.

Тус хэлтсийн Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн нь 2016 оны эхний хагас жилийн байдлаар удирдамж боловсруулан сангийн зарим үйл ажиллагаанд 3 удаагийн хяналт шалгалт хийж, хяналт шалгалтын ажлын тайлан, зөвлөмжийн дагуу гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө боловсруулан, зөвлөмжийн биелэлтийн тайланг тухай бүр гаргуулан, эхний хагас жилийн ажлын тайлантай хамт архивлаж хадгалсан байна.

Эхний хагас жилд хийгдсэн хяналт шалгалтаар сангийн 2014-2015 оныг хамруулан дараах шалгалтуудыг хийсэн байна. Үүнд:

1. Нийгмийн халамжийн хууль, тогтоомжийн хэрэгжилт, тэтгэвэр тэтгэмж авагчийн хувийн хэргийн бүрдэлт, тэтгэвэр тэтгэмжийн олголт, зарцуулалт, нөхцөлт мөнгөн тэтгэмж, авагч иргэдийн бичиг баримтын бүрдүүлэлт, зарцуулалтад хийсэн шалгалтаар 12 зөвлөмж өгч гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө боловсруулан зөвлөмжийн биелэлтийг хангуулан ажилласан
2. Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний 2015 оны олголт, зарцуулалт, хувийн хэргийн бүрдэлд хийсэн шалгалтаар 583.8 мянган төгрөгийн зөрчил илэрснийг арилгуулж, иргэдэд журамд заагдсан 10 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний талаар мэдээлэл хүргэж зөвлөмж өгсөн

3. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний талаарх хяналт шалгалтыг Баянтал, Шивээговь сумдад хийсэн байна.

Сүүлийн хагас жилд хяналт шалгалтын ажил хийгдээгүй, ажлын төлөвлөгөө, тайлан байхгүй байна.

Мөн сумдад олгогдож буй хүнсний эрхийн бичгийг ХХҮЕГ-аас хариуцсан мэргэжилтэнд шуудангаар ирснийг сумдын Нийгмийн ажилтанд хүлээлгэн өгч холбогдох өрхүүдэд хуваарилж байгаа боловч аймгийн ХХҮГ болон холбогдох мэргэжилтэн, нийгмийн ажилтнууд шат шатандаа анхан шатны баримтыг бүрдүүлж ажиллаагүй байна.

Үнэт цаасыг данс бүртгэлд тусгаагүйгээс гадна зорилтот бүлэгт бүрэн олгосон эсэх нь тодорхойгүй байна. Баянтал сумын мэргэжилтэн Болормаа иргэдэд олгохдоо хүнсний эрхийн бичгийн жагсаалтыг талоны дугаар болон гарын үсэг зуруулалгүй олгосон байна.

Мөн Шивээговь сумын зорилтот бүлгийн иргэдэд олгосон 2016 оны эхний 2 сарын санхүүжилтийн 897.0 мянган төгрөгийг аймгийн ХХҮГ-аас “Шивээ сервис” ХХК-д олгоогүй, жилийн эцсийн тайлан тэнцэлд өглөгөөр тусгаагүй байна.

Энэ нь сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байсныг харуулж байгаа бөгөөд аймгийн Хөдөлмөрийн хэлтэс, Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсүүд бүртцийн өөрчлөлтөөр нэгтгэхэд тус хэлтсүүдийн дарга, хариуцсан мэргэжилтэн болон сангийн нягтлан бодогч нар олон удаа солигдсон, хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан ажилтны орон тоонд хүн авч ажиллуулалгүй өөр мэргэжилтэнд давхар хариуцуулсан боловч хяналт шалгалтын ажил огт хийгдээгүй зэргээс дотоод хяналт суларсан байна.

2016 онд Халамжийн сангийн үйл ажиллагаанд бусад байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 149 мэдээлэл байршуулснаас 91 мэдээллийн хугацаа хоцорсон төлөвтэй байна. Энэ нь Халамжийн сангийн мэргэжилтэн олон удаа солигдсон, ажил хүлээлцэхдээ Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нэвтрэх нэр, нууц үг зэргийг бүрэн хүлээлцээгүй, энэ талаар бүрэн ойлголтгүй байсантай холбоотойгоор шилэн дансны мэдээлэл хоцорсон байна.

Иймд сангийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах, шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж хэвших талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

2.5 Бүртгэл мэдээллийн нэгдсэн санд Халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн мэдээллийг бүрэн оруулсан байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу халамжийн үйлчилгээ авч буй иргэдийн судалгааг <http://wais.hudulmur-halamj.gov.mn> програмд бүрэн шивж оруулсан байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах хүсэлт гаргасан иргэдэд халамжийн олгох тухай шийдвэр гарснаар мэдээллийн санд баяжилт хийгдэж байна.

Уг програмаас нийт халамжийн үйлчилгээнд хамрагдаж буй иргэдийн тоо нь халамжийн үйлчилгээний нэр төрөл тус бүрээр давхардсан тоогоор гарч байгаа боловч нийт үйлчилгээний хэдэн хувийг хэдэн иргэн авч байгаа болон хэдэн иргэн хэд хэдэн үйлчилгээнд зэрэг хамрагдаж байгаа талаар нэгдсэн статистик судалгаа гарах боломжгүй байна.

Иргэдийн шилжилт хөдөлгөөн болон нас барсан иргэдийн мэдээллийг аймгийн УБХ-ээс сар бүрийн 02-ны дотор судалгааг гаргаж ирүүлснээр дээрх програмд өөрчлөлт хийгдэж байна. Аймгийн УБХ-тэй хамтран ажиллах гэрээ хийгдээгүй боловч халамжийн үйлчилгээний давхардал үүсэхээс сэргийлэх зорилгоор аймгаас шилжсэн болон нас барсан иргэний мэдээллийг авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Шинээр үйлчилгээ авч буй иргэдийн мэдээллийг өөрсдөө хүсэлт гаргасан тохиолдолд нэгдсэн програмд оруулахад дараа сарын халамжийн үйлчилгээнд хамруулах болон хамрагдах боломжгүй талаар ХХҮЕГ-аас хянаж, эрхийг нээж байна.

2016 ОНД ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ИРГЭДИЙН ТОО, ХУВИАР



Диаграмаас харахад: халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо давхардсан тоогоор тэтгэвэр тэтгэмжид 6.0-24.0 хувь, хөнгөлөлт, тусламжийн үйлчилгээнд 0-28.0 хувь нь хамрагдсан байна.

Халамжийн үйлчилгээнд шинээр хамрагдах буюу хүнсний эрхийн бичиг авах хүсэлт гаргаж өргөдөл өгсөн өрхөөс Өрхийн мэдээллийн сангийн судалгааны мэргэжилтэн Үндэсний статистикийн хорооны дарга, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2013 оны 123/165 дугаар тушаалаар батлагдсан Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааны асуулгын маягтаар

судалгааг авч програмд оруулахад ХХҮЕГ-аас уг судалгааг боловсруулж босго оноонд хүрсэн эсэхийг тодорхойлон хүнсний эрхийн бичиг авах боломжтой өрхийн мэдээлэл нь олголт хийх жагсаалтад автоматаар нэмэгддэг байна.

Энэ нь тухайн мэргэжилтэн ямар аргачлалаар босго оноог тооцоолсныг харах боломжгүй байгаа бөгөөд дээрх асуулгын маягт нь хэт ерөнхий асуултуудтай байна. 2016 онд хүнсний эрхийн бичиг авч буй 1 өрх хасуулах тухай хүсэлт гаргасны дагуу эрхийн бичгийн олголтыг зогсоосон байна.

Энэхүү хөнгөлөлтийн журамд тухайн өрх, иргэд өөрсдөө хүнсний эрхийн бичгийн хөнгөлөлтөд хамрагдах болон хасуулах тухай хүсэлтийг гаргаагүй тохиолдолд ямар нэгэн хөдөлгөөн хийгдэхгүйгээр зохицуулагдсан нь өрөөсгөл байгаа бөгөөд уг үйлчилгээний талаарх мэдээлэл, ойлголтгүй иргэд олон байх магадлалтай юм.

Иймд дээрх хөнгөлөлт болон халамжийн үйлчилгээнд хамрагдах шаардлагатай иргэдийг бүрэн хамруулахын тулд багийн Засаг дарга болон Нийгмийн ажилтнуудтай уялдаа холбоотой ажиллах, холбогдох хууль, тогтоомжийн талаар иргэдэд тогтмол мэдээлж, сурталчилж байх нь зүйтэй юм.

2.6 Халамжийн сангийн 5 төрлийн мэдээ, тайланг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн байна.

Халамжийн сангийн хөрөнгийн орлого, зарлагын мэдээ тайланг сар бүр болон хагас, бүтэн жилээр гаргаж дараах байгууллагуудад хүргүүлж ажилласан байна. Тухайлбал:

- ХХҮЕГ-т сар бүрийн 02-ны дотор,
- Аймгийн Статистикийн хэлтэст сар бүрийн 03-ны дотор,
- Санхүү, төрийн сангийн хэлтэст сар бүрийн 10-ны дотор
- Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэст сар бүрийн 20-ны дотор,
- Санхүүгийн тайланг ХХҮЕГ болон аймгийн СТСХ-т хагас, бүтэн жилээр гаргаж цаг тухайд нь хүргүүлж ирсэн байна.

Аймгийн Халамжийн сангийн орлого, зарлагын мэдээ тайлангийн хувьд 2016 онд 5 төрийн 50 удаагийн мэдээ, тайланг хүргүүлсэн байна.

Аудитаар нийт 31,239.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 332.8 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 10,516.0 мянган төгрөгийн албан шаардлага өгч, зөрчлийг арилгуулах 8 зөвлөмж өглөө.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

1. Төсвийн төлөвлөлтийг тухай бүр хийгээгүй, батлагдсан орон тоонд хүний нөөцийг бүрэн ажиллуулаагүйгээс үүссэн төсвийн үлдэгдлийг төлөвлөгдөөгүй зардалд зарцуулсан байна.
2. Байгууллагын үндсэн чиг үүргийн хэрэгжилт, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллаагүйгээс нягтлан бодох бүртгэлийг холбогдох хууль, журам, стандартын дагуу зохих ёсоор хөтлөөгүй байна.
3. Үндсэн хөрөнгийн шинж чанартай 9,619.0 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн, ашиглах боломжгүй болсон, хуримтлагдсан элдэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг эрх бүхий байгууллагад санал хүргүүлж шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.
4. Ашиглах боломжгүй болсон 30,000.0 мянган төгрөгийн зураг төсвийн үнэ нийт үндсэн хөрөнгийн 14.0 хувийг эзэлж байна.
5. Халамжийн сангийн төсвийг үндэслэлтэй төлөвлөж, батлуулаагүйгээс жил бүр төсвийн 75.9-81.8 хувийг зарцуулсан байна.
6. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хуулиар тодорхойлсон иргэдийг бүрэн хамруулах талаар хийсэн судалгаа, шинжилгээний ажил дутагдалтай байна.
7. Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
8. Бүртгэл мэдээллийн нэгдсэн санд Халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн мэдээллийг бүрэн оруулж, мэдээ, тайланг хугацаанд нь тайлагнасан байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

Аймгийн ХХҮГ-ын даргад:

1. Батлагдсан орон тоо дутуу ажиллуулснаас бий болсон цалингийн сангийн үлдэгдлийг үр дүнгийн болон мөнгөн урамшуулалд олгохгүй байх
2. Тушаал шийдвэр гаргахдаа хууль эрхийн актын үндэслэлийг сайтар хянах, албан хаагчдад үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгохгүй байх,
3. ХХҮЕГ-аас үнэ төлбөргүй ирүүлж буй үнэт цаасыг НБББББ-ийг баримтлан данс бүртгэлд тусгах
4. Үндсэн хөрөнгийн шинж чанартай 9,619.0 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд шилжүүлэн бүртгэх, НБББББ-ийг мөрдөж ажиллах, үнэт цаасны орлого, зарлагын зарцуулалтад тавих шат шатны хяналтыг сайжруулж, бүртгэлийг бүрэн хөтөлж хэвших
5. Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгүүдийг данснаас хасах, эсхүл цаашид ашиглах боломжтой гэж үзсэн тохиолдолд хөрөнгийн ашиглах хугацаа, үнэлгээг тогтоох,
6. Засварлах боломжгүйгээр эвдэрсэн хөрөнгийг холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрээр данснаас хасаж, ХХААГ-т ашиглагдаж байгаа хөрөнгийн болон зураг төсвийн асуудлыг эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх
7. Байгууллагын болон Халамжийн сангийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах, шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж хэвших
8. Халамжийн үйлчилгээнд хуулиар тодорхойлсон иргэдийг бүрэн хамруулахын тулд сумын болон багийн Засаг дарга, нийгмийн ажилтнуудтай ажлын уялдаа холбоотой ажиллах, хууль тогтоомж, холбогдох журмуудыг сурталчилах ажлыг сайжруулах

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ

Аймгийн ХХҮГ-аас ирүүлсэн санал:



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг,
Утас/факс: (976) 7054 3518,
E-mail: govsumben.hudalmor.hulamj@gmail.com

2017-06-19 № 01/305

талай _____ -ны № _____ -т

Санал хүргүүлэх тухай

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЪЯА
ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Т. Наранбаларт
*Саналыг судалж, зөвлөмж
мэргэжилтэнтэй саналыг
тайланг туурамч
ордуулах*

17/1

Тус газрын 2016 оны үйл ажиллагааны үр дүн болон Халамжийн сангийн 2016 оны санхүүгийн үйл ажиллагаанд Гүйцэтгэлийн аудит хийсэн тухай тайлан, дүгнэлт, зөвлөмжтэй танилцаж, хүндэтгэлтэй хүлээн авч дараах саналыг хүргүүлж байна.

ҮҮНД:

1. Тус Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын үйл ажиллагааг шалгаж гаргасан дүгнэлт болон дарга надад хүргүүлсэн зөвлөмжтэй сайтар танилцаж, цаашдын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах болно.
2. Үйл ажиллагааны нягтлан бодогч Б.Азаяад олгосон 560,8 мянган төгрөгийн мөнгөн урамшууллын тушаалын үндэслэл болох хуулийн заалтыг буруу хэрэглэж, агуулгын хувьд алдаатай тушаал гарсан байгааг хүлээн зөвшөөрч байна. Цаашид тушаалын хууль эрх зүйн үндэслэлийг зөв хэрэглэхэд анхаарч ажиллах тул алдааг давтахгүй байх талаар зөвлөмжинд тусгуулах саналаа хүргүүлж байна.
3. Шалгалтаар 976,5 мянган төгрөгийн акт тавигдсан байгаагийн 415,7 мянган төгрөгийн акт нь үр дүнгийн шагнал авсан атлаа давхардуулан цалингийн шатлал нэмэгдүүлсэн байгаа нь буруу гэж үзэж акт тавьсан байна. Мэргэжилтэн Отгонцэцэг нь 2016 оны эхний хагас жилээр үр дүнгийн гэрээгээр А үнэлгээ авсантай холбогдуулан цалингийн шатлалыг нэмэгдүүлсэн байгаа ба хагас жилээр үр дүнгийн шагнал аваагүй байна. Мөн Шивээговь сумын мэргэжилтэн Б.Базаррагчаа нь 2013 оны жилийн эцсийн үр дүнгээр "А" үнэлгээ авсан тул Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн даргын 2014 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн Б/05 тоот тушаалаар шатлалыг нэмэгдүүлж үр дүнгийн шагнал олгоогүй байна. Иймд 415,7 мянган төгрөг нь 2016 онд энэ 2

мэргэжилтний шатлал ахисанаас нэмэгдсэн цалингийн тооцоо байгаа тул эргэн нягтлаж актнаас чөлөөлж өгнө үү

4. Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан гэж үзэж 4 411,2 мянган төгрөгийн албан шаардлага ирүүлсэн байгаад дараах тайлбарыг хийж байна. Өмнөх бүтцээр ажиллаж байсан хэлтсүүд нь бүх ажилчдын цалингаа 8 сар дуустал, ТҮ-ийн ажилчдын цалинг 9 сар дуустал бүх ажилчид амралтын цалин авсан тул цалингийн сан хүрэлцээгүй болж, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт санал хүргүүлснээр 11 дүгээр сарын төсвийн хуваарьт өөрчлөлт оруулсан. Бүрэн орон тоогоор ажиллахад цалин сан хүрэлцэхээргүй байсан ба Дэд даргын Авлигатай тэмцэх газрын бичиг ирээгүйгээс он гаргаж авсан. Иймд зөвлөмж болон тавигдаж буй шаардлага, хуулийн агуулгыг сайтар ойлгосон тул зөвлөмжид тусгаж өгнө үү.
5. Үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн байгаа 9619,0 мянган төгрөгийг зохих журмын дагуу бүртгэлд тусгахаар болов.
6. Халамжийн сангаас олгодог хүнс тэжээлийн эрхийн бичгээр 2016 онд иргэдэд үйлчилж байсан Шивээ-Сервис ХХК-тай тооцоо нийлж, төлбөрийг барагдуулна.

ДАРГА



Д. ГАНСҮХ

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ХИЙСЭН ТАЙЛБАР

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас ирүүлсэн саналтай танилцаад дараах тайлбарыг өгч байна. Үүнд:

1. ХХҮГ-ын үйл ажиллагааны нягтлан бодогчид мөнгөн урамшуулал олгох тушаалын үндэслэл буруу байсан боловч шагнал, урамшуулал давхардаж олгогдоогүй тул цаашид тушаал шийдвэр гаргахдаа хууль эрхийн актын үндэслэлийг хянаж, зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.
2. Мэргэжилтэн Б.Отгонцэцэгийн цалингийн шатлал нэмэгдүүлэх тухай тушаалд “2015 оны үр дүнгийн гэрээнд маш сайн буюу А үнэлэгдсэн тул” гэсэн бөгөөд НХҮХ-ийн 2015 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/36 дугаар тушаалаар 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний үр дүнгийн урамшуулал олгосон байгаа нь үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5-д “төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх” гэснийг зөрчиж байгаа тул төлбөрийн актыг хэвээр үлдээлээ.
3. Мэргэжилтэн Б.Базаррагчаагийн цалингийн шатлалыг 2013 оны үр дүнгийн гэрээний дүгнэлтийг үндэслэн 2014 оны 05 дугаар сард цалингийн шатлалыг нэмэгдүүлсэн боловч 2014 оны 10 дугаар сард 2013 оны ажлын үр дүнгийн урамшуулал болгон 200.0 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна. Иймд Б.Базаррагчаагийн цалингийн шатлалын зөрүүгээр бус давхардуулан олгосон үр дүнгийн урамшуулалд төлбөрийн акт тогтоохоор тайланд өөрчлөлт оруулав.
4. Тус газар нь бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор батлагдсан орон тоо дутуу ажилласнаас үүссэн цалингийн сангийн үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлэлгүй албан хаагчдын үр дүнгийн урамшуулалд зарцуулсан зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.